



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний
холбоонд тавигдах нөхцөл шаардлага” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 49.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд тавигдах нөхцөл шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Д.Нямцэрэн/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

МОНГОЛЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 49.2 дахь хэсэгт заасны дагуу Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан холбоо “Үндэсний холбоо” гэх тодотголыг оноосон нэрд хэрэглэнэ.
2. Үндэсний холбоо нь дараах шаардлагыг хангасан байна:
 - 2.1. Үндэсний холбоо нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэр, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байх;
 - 2.2. Үндэсний холбооны дүрэм нь ХЗХ-ны үйл ажиллагааны зарчимд нийцсэн байх;
 - 2.3. Үндэсний холбооны гишүүнчлэл нь Монгол улсын бүс нутгийн хүрээг хамгийн өргөн хүрээнд хамарсан нийслэл, орон нутгийн ХЗХ-дын 50-иас доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэнбайх;
 - 2.4. ХЗХ-дын холбоо нь үүсгэн байгуулагдсанаас хойш 2 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа тогтмол явуулж, туршлага хуримтлуулсан;
 - 2.5. Монголын хоршооллын хөдөлгөөнийг дэмжин “Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо”-нд гишүүнээр элсэн хамтран ажилладаг;
 - 2.6. Гадаад орны ХЗХ-дын холбоодтой түншлэлийн харилцаа тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлж чадсанбайх;
 - 2.7. ХЗХ-дын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө боловруулсан, ХЗХ-дод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх,техник хэрэгслийн болон боловсон хүчний чадавхитай байх;
 - 2.8. Үндэсний холбоо нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан бүтэц, зохион байгуулалттай, чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.
3. Үндэсний холбоонд тавигдах шаардлага хангагдсан болохыг Хорооны шийдвэрээр тодорхойлж, Хадгаламж, зээлийн хоршооны тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.